

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-4
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	3
2.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн/	3-4

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
10 дугаар сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ч.Анар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Н.Батсүмбэрэл, Х.Булгантуяа, Ш.Бямбасүрэн, Б.Жаргалан, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, Б.Найдалаа, Б.Пунсалмаа, А.Ундраа, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо хариуцсан референт Т.Билэг-Өрнөх, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо хариуцсан референт М.Мандхай, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Байнгын хорооны тогтоолоор байгуулагдах ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрс тодорхой бус, ирээгүй байгаа тухай мэдэгдэж, уг асуудлыг түр хойшлуулав./14:44/

Уг асуудлыг 14 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Аялал жуулчлалын хөгжлийн дэд

хороо хариуцсан референт Т.Билэг-Өрнөх, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо хариуцсан референт М.Мандхай, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Монгол Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдах Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүний нэрс Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасан дагуу хувь тэнцүүлсэн байдлаар ирээгүй байгаа тухай мэдэгдэж, уг асуудлыг хэлэлцэхийг хойшлуулав./14:45/

Уг асуудлыг 14 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 03 минут үргэлжилж, 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 42 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Ринчиндоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Жамбалын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Болдын Жавхлан, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Буяагийн Тулга, Болдын Уянга, Мөнхчулууны Энхцэцэг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 56.3 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Энэ нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

2. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл/Ухаа худаг ордын ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн Оюун-Эрдэнэ нарын 34 гишүүн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн. Энэ 2 асуудал маань.

Нэгдүгээр асуудал. Ажлын хэсэгт орох гишүүдийн нэрс тодорхой бус ирээгүй байна. Ийм учраас энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас хойшлуулъя.

14.44 цаг

Хоёрдугаар асуудал дээр “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр Хяналт шалгалтын тухай хуулийн 33.2 Түр хорооны бүрэлдэхүүнийг тогтоохдоо Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэх боловч Түр хорооны бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байх, Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчмыг баримтална гэж хууль дээр заасан байна.

Яг энэ хувь тэнцүүлсэн одоо байдлаар нэрс орж ирээгүй байгаа учраас нэгдүгээрт одоо Ногоон намаас огт нэр өгөөгүй байна. Хоёрдугаарт нь олонхоос ирүүлсэн нэр цөөнхийн нэр 2, олонхоос ирүүлсэн нэр цөөнхөөс ирүүлсэн нэр 2 хувь тэнцүүлсэн байдлаар ирээгүй байна. Ийм учраас энэ асуудлыг хойшлуулъя.

Ингээд хэлэлцэх асуудал байхгүй байна. Тэгээд өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

14.45 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР